



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“БАЯНХОНГОР АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ОРЛОГОД
БАЙГАЛЬ ОРЧНООС ОРЖ ИРЖ БАЙГАА ХӨРӨНГӨ
ТӨВЛӨРҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ ҮР ДҮН /2020-2021/-Д
ХЙИСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Байгалийн нөөц ашиглалтад тавих төрийн байгууллагуудын хяналт сул, ажлын уялдаа хангалтгүйгээс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг бүрэн ногдуулахгүй байна.

АУДИТЫН КОД: БНА-2022/31-1-ШТА-ГА

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын **дарга,**
тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 цахим хуудас: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер А.Цээням

Утас: 70442424 цахим хуудас: tseenyma@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Азбаяр

Утас: 99061429 цахим хуудас: azbayarb@audit.gov.mn

Аудитор Ж.Өсөхбаяр

Утас: 99890393 цахим хуудас: usukhbayarj@audit.gov.mn

Аудитор Н.Бүнчинсүрэн

Утас: 99049866 цахим хуудас: bunchinsurenn@audit.gov.mn

Баянхонгор хот 2022 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.tailan.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	3
БҮЛЭГ 1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ ТАЛААР “АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГОД ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭГ ОРОН НУТГИЙН ТҮВШИНД ЗОХИХ ХЭМЖЭЭГЭЭР ТӨЛӨВЛӨН ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА.	5
1.1. Аймаг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, жил жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зарим зорилт бүрэн хангагдаагүй байна.	5
1.2. Үндэсний болон дэд хөтөлбөрүүдэд тусгагдсан зорилт арга хэмжээний хэрэгжилтийг гаргаж дүгнэсэн байна.	11
БҮЛЭГ 2. АЖИЛ ХАРИУЦСАН БАЙГУУЛЛАГУУД ХУУЛИАР ТОГТООСОН ЧИГ ҮҮРГЭЭ БҮРЭН БИЕЛҮҮЛЭЭГҮЙГЭЭС УС РАШААН АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ОРЛОГО БҮРЭН ТӨВЛӨРӨХГҮЙ ӨМНӨХ АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ ДАВТАГДАЖ БАЙНА.	14
2.1. Ан, амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогыг журмын дагуу валютын ханшаар зөв тооцоогүйгээс төсөвт дутуу төвлөрүүлсэн, Шонхорын өгөөшний орлогыг тооцож аваагүй байна.	14
2.2. Ан, амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг хуульд заасан хэмжээгээр төлөвлөхгүй байна.	17
2.3. Ус, рашаан ашигласны төлбөрийн орлогыг бодитой төлөвлөөгүй, ус ашиглагчийн ус ашиглах үйл ажиллагаанд тавих мэргэжлийн эрх бүхий байгууллагууд хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс ус, рашаан ашигласны төлбөрийн орлогыг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлээгүй байна.	19
2.4. Ус, рашаан ашигласны төлбөрөөс байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хувь хэмжээг хуульд нийцүүлэн төлөвлөөгүй, хэрэгжүүлэх арга хэмжээг аймгийн ИТХ-аар батлаагүй байна.	24
2.5. Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагыг барагдуулсан ч, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.	26
БҮЛЭГ 3. УУЛ, УУРХАЙН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ ЗАРИМ КОМПАНИ ОРЛОГЫГ ДУТУУ ТӨВЛӨРҮҮЛСЭН БАЙНА.	27
3.1. Уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдээс орох орлогыг бүрэн төвлөрүүлээгүй байна.	27
3.2. Уул, уурхайн үйл ажиллагааны хүрээнд төвлөрсөн орлогын эх үүсвэрээр хийсэн хөрөнгө оруулалтын үр дүнг тооцоогүй, төсвийн бүрэлдэхүүнд оруулаагүй зарцуулсан байна.	29
АУДИТЫН ДҮГНЭЛТ:	33
АУДИТЫН ЗӨВЛӨМЖ:	34
ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ:	36

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
ҮАГ	Үндэсний аудитын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
МУЕА	Монгол Улсын ерөнхий аудитор
ХБТХОТ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ХШҮХ	Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2022 оны “Аудитын сэдэв батлах тухай” А/11 дүгээр тушаал, “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн хийв.
Аудитын зорилт	Баянхонгор аймгийн орон нутгийн орлогод байгаль орчноос орж ирж байгаа хөрөнгө төвлөрүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.
Аудитын хамарсан хүрээ	Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд: ➤ Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлж байгаа эсэх. ➤ Ан, амьтны нөөц, ус рашаан ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлт, төвлөрүүлэлт, зарцуулалт хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх. ➤ Уул, уурхай, нөхөн сэргээлтээс орох орлогын төвлөрүүлэлт, зарцуулалт үр дүнтэй эсэх. Аудитад аймаг, сумдын Засаг дарга, ЗДТГ-ууд, Бөөнцагаан орог нуурын сав газар, аймгийн БОАЖГ, Мэргэжлийн хяналтын газрын 2020, 2021 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, ус ашиглах дүгнэлт, гэрээ, ажлын гүйцэтгэл, хөрөнгийн орлого, зарлагын баримтыг хамруулан гүйцэтгэлийн аудитыг хийв. Баянхонгор аймагт 2020-2021 онд ан, амьтан, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоор нийт 1,081.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 2,675.8 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн. Баянхонгор аймаг нь уул уурхай аж ахуйн нэгжүүдийн хандив тусламжийн орлогоор 2020-2021 онд 1,777.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр 689.4 сая төгрөгийн хандивыг төсөвт төвлөрүүлсэн байна.
Аудитын хязгаарлалт	Аудитад уул, уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй компаниуд, рашаан ашиглагч “Шаргалжуут рашаан сувилал” ХХК, “Баян-Ундрага Зэндмэнэ” ХХК, Амар амгалан рашаан сувилал, Сумдын 2020, 2021 оны ан, амьтан агнуулсан орлого зэргээс бусад ААНБ-ын үйл ажиллагааг хамааруулаагүй болно.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУБ(INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, гүйцэтгэлийн аудит хийх аргачлалыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийж, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авч, харьцуулалт хийн, нэгтгэн, дүн шинжилгээ хийж, аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер А.Цээням хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Азбаяр, аудитор Ж.Өсөхбаяр, Н.Бүнчинсүрэн нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Аудитын талбарын үе шатны ажлыг 2022 оны 09 дугаар сарын 07-оос эхлэн гүйцэтгэсэн ба аудиторууд талбарын ажлын явцад тайлангийн төслийг бичиж, аудитын тайланг удирдлагын зөвлөлийн хурлаар 10 дугаар сарын 10-ны өдөр хэлэлцүүлж, тайланг баталгаажуулан Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон бусад холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.

**Хүндрэл
бэрхшээл**

Байхгүй

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДҮН

БҮЛЭГ 1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ ТАЛААР “АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГОД ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭГ ОРОН НУТГИЙН ТҮВШИНД ЗОХИХ ХЭМЖЭЭГЭЭР ТӨЛӨВЛӨН ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА.

1.1. Аймаг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, жил жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зарим зорилт бүрэн хангагдаагүй байна.

1.1.1 Дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай эх үүсвэрийг бодитой тооцож, төлөвлөөгүй байна.

Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 6 дугаар бүлэгт “Ногоон хөгжил” зорилгын хүрээнд 4 үндсэн зорилт дэвшүүлсэн байна.

Ногоон хөгжил зорилтын хүрээнд Баянхонгор аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд дараах байдлаар тусгасан байна.

Хүснэгт №1. Дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгийн төлөвлөлт

№	Бодлогын баримт бичиг	Дэвшүүлсэн зорилт	Арга хэмжээ	Санхүүжилт	
				Эх үүсвэр	Дүн /сая төг/
Дунд хугацааны бодлого					
1	Баянхонгор аймгийн ногоон хөгжлийн хэтийн зорилт-2028	7	187	Улсын төсөв, ОУБ, ОНТ, Хөгжлийн хөтөлбөр	1,380,745.0
2	Аймгийн засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр /2016-2020/		11		
3	Аймгийг хөгжүүлэх 2021-2025 оны таван жилийн үндсэн чиглэл	3	11		
4	Аймгийн засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр /2021-2024/	3	23		
Богино хугацааны бодлого					
1	Аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	1	12	ОНХС ОНТ БХНСАХЗ	522.0
2	Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөө	2	21	ОНХС ОНТ БХНСАХЗ бусад	1,550.1
Аймгийн дэд хөтөлбөр					
1	"Агаар хөрс усны бохирдлыг бууруулах" дэд хөтөлбөр	4	35		

Эх сурвалж: Аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүд

Аймгийн Засаг даргын 2017 оны А/654 дүгээр захирамжаар ногоон хөгжлийн дунд хугацааны хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг 23 хүний бүрэлдэхүүнтэй

байгуулсан байна. Үүнд: Аймгийн БОАЖГ, ЗДТГ-ын ХБТХОХ, Ус цаг уур орчны шинжилгээний газар, Статистикийн хэлтэс, Хүнс, Хөдөө, аж ахуйн газар зэрэг төрийн байгууллагуудын төлөөллүүдийг оролцуулан ажлын хэсэг байгуулснаас харахад бодлого хэрэгжүүлэх талуудын оролцоог хангасан байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийг хөгжүүлэх 2021-2025 оны таван жилийн үндсэн чиглэл зэрэг дунд болон богино бодлогын баримт бичгүүдийг аймгийн ИТХ-аар хэлэлцэн баталсан байна.

Дээрх дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулахдаа аймгийн БОАЖГ, “Бөөнцагаан Орог нуур” сав газрын захиргаа, Баянхонгор сумын ЗДТГ, “Цэвэр хот” ОНӨААТҮГ, “Чандмань-Баянхонгор” ХК, аймгийн Засаг даргын дэргэдэх “Гадаад харилцаа, аялал жуулчлалын алба”, Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргаа зэрэг газруудаас саналыг авч тусгасан байна.

Аудитын илрүүлэлт

Баянхонгор аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг батлахдаа шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг тооцож төлөвлөөгүй байна.

Иймд Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.7.2.б¹, 6.7.2.в² заалт, Засгийн газрын 2021 оны 119 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 3 дугаар хавсралтад нийцүүлэн аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж, батлуулах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

1.1.2. Аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргаа удирдлагын хэлтэс нь дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тогтоосон хугацаанд тайлагнаж ИТХ-аар дүгнүүлсэн байна.

Баянхонгор аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан “Ногоон хөгжил” зорилтын хэрэгжилтийг аймгийн ИТХ-аар хэлэлцэж дүгнэсэн байна. Тухайлбал:

¹ Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг тооцсон төсөл, арга хэмжээг тусгасан хөтөлбөрийг хавсаргах;

² Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан зорилго, зорилт, хүрэх үр дүнд уялдуулан орон нутгийн аливаа онцлогийг харгалзан зорилго, зорилт, хүрэх үр дүн, тоон болон чанарын шалгуур үзүүлэлт, тухайн шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх зорилтот түвшинг орон нутгийн түвшинд шинээр тодорхойлж болно.

Хүснэгт №2. Дунд болон богино хугацааны баримт бичгийн хэрэгжилт

д/д	Шалгуур үзүүлэлт	Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт		Аймгийн Эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт		Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2021 оны хэрэгжилт		Аймгийн хөгжлийн төлөвлөгөөний 2021 оны жилийн эцсийн хэрэгжилт	
		тоо	хувь	тоо	хувь	тоо	Хувь	тоо	Хувь
1	Үр дүнтэй 100% /90-100хувь/	10	90.9	7	70.0	1	9.1	18	85.7
2	Тодорхой үр дүнд хүрсэн /60-89 хувь/	1	9.1	1	10.0	3	27.3	2	9.5
3	Эрчимжүүлэх шаардлагатай /31-59 хувь/ 40%			1	10.0	6	54.5		0
4	Үр дүнгүй 0 /0-30 хувь/			1	10.0	1	9.1	1	4.8
5	Үнэлэх боломжгүй						0		0
	Нийт дүн	11	100.0	10	100.0	11	100.0	21	100.0

Эх сурвалж: Аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайлангаас

Дээрх хүснэгтээс харахад аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан “Ногоон хөгжил” зорилтын зарим арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй байна.

Аймгийн ИТХ-аас дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт дараах арга хэмжээнүүдийг үр дүнгүй буюу хэрэгжээгүй гэж дүгнэсэн байна. Үүнд:

1. Баянхонгор сумын хогийн цэгийг шинэчлэх
2. Хүлэмжийн хийн ялгарлыг 10 хувь бууруулах
3. Эрдэнэмандал хайрхныг моджуулж ногоон байгууламжийг нэмэгдүүлэх

Дээрх төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй, дутуу хэрэгжсэн нь аймгийн 2021-2025 оны хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахдаа зорилт арга хэмжээ бүрээр шалгуур үзүүлэлтийг урьдчилан тодорхойлоогүй, суурь түвшний судалгаагүй, зорилт хүрэх түвшнийг тодорхойгүй зэрэг зохион байгуулалт, төлөвлөлтийн алдаа, тухайн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн санхүүжилт дутуу орж ирсэн зэргээс шалтгаалжээ.

Аудитын илрүүлэлт

Аймгийн ИТХ-ын 2018 оны 10/1 дүгээр тогтоолоор баталсан “Баянхонгор аймгийн ногоон хөгжлийн хэтийн зорилт-2028” дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тусгайлан дүгнэж биелэлтийг тооцоогүй байна.

Иймд бодлогын баримт бичгийг боловсруулахдаа бодит тоо, судалгаа, хэрэгжих бололцоотой эсэхэд дүн шинжилгээ хийж, батлагдсан бодлогын болон төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийг аймгийн ИТХ-д тайлагнах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

1.1.3. Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс нь дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүрэг бүхий нэгж нь 2016-2020 онд Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, 2021 оноос Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс гэсэн нэршилтэй болжээ.

Аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт аймгийн ЗДТГ-ын ХШҮХ нь жил бүр хяналт шинжилгээ, үнэлгээ хийжээ.

“Баянхонгор аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2021 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийхэд зорилт арга хэмжээний суурь түвшингийн судалгааг 2020, 2021 оноор гаргаагүй, 2022-2025 онд хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг боловсруулаагүй, тайлангийн хэрэгжилт хангалтгүй, хугацаа хожимдож ирүүлдэг, суурь болон хүрсэн түвшинтэй харьцуулан бодит үр дүнгээр тайлагнадаггүй зэрэг зөрчилд 2022.01.09-ний өдөр илтгэх хуудсаар 8 зөвлөмжийг өгсөн боловч хэнд хүргүүлсэн нь тодорхойгүй байна.

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтэс нь аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт, Баянхонгор аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж 2021.02.17-ний өдрийн 04 тоот албан бичгээр аймгийн Засаг даргад 6 зөвлөмж өгсөн байна.

Дээрх баримт бичгийн ногоон хөгжлийн бодлого зорилтын хүрээнд баталсан 11 арга хэмжээнээс утаагүй түлшний үйлдвэрлэл эрхлэх аж ахуй нэгж, иргэдийг дэмжих арга хэмжээ нь 70 хувь, бусад арга хэмжээг бүрэн хэрэгжсэн гэж дүгнэсэн.

Хүснэгт №3. Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжээгүй заалт

Зүйл, заалт	Хэрэгжилт	Хувь
Утаагүй түлшний үйлдвэрлэл эрхлэх аж ахуй нэгж, иргэдийг дэмжинэ	Агаар, хөрс, усны бохирдол бууруулах дэд хөтөлбөрийг боловсруулах аймгийн Засаг даргын 2017 оны А/50 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулан, хөтөлбөрийн төслийг боловсруулсан. Тус хөтөлбөрт утаагүй түлшний үйлдвэрлэл эрхлэх аж ахуй нэгж иргэдийг дэмжих талаар төлөвлөгөөнд тусгасан. Говь хээрийн бүсэд шахмал түлшний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, аймгийн төв, суурин газрын түлшний модны хэрэглээ агаарын бохирдолын багасгах зорилгоор Баян-Өндөр, Баянцагаан, Шинэжинст сумдад шахмал түлш үйлдвэрлэж байна.	70

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр

Аудитаар 70 хувьтай үнэлэгдсэн тус арга хэмжээний хэрэгжилтийг холбогдох сумдын Санхүүгийн албаны дарга нараас тодруулахад Баян-Өндөр, Баянцагаан,

Шинэжинст сумуудад шахмал түлшний үйлдвэр байхгүй байгаа нь үнэлгээ бодит бус байна.

Аудитын илрүүлэлт

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтэс нь бодлогын баримт бичгийн биелэлтэд хяналт шинжилгээ хийж байгаа боловч, зарим зөвлөмжид биелэлтийг тооцох хугацаа, хариуцах эзэнг бичээгүй, хүргүүлсэн эсэх нь тодорхойгүй байна.

Дээрх зөрчил нь Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ийн 5.1.3³ дэх заалтыг зөрчсөн байна.

Иймд зөвлөмжид биелэлтийг тооцох хугацаа, хариуцах эзэнг тодорхой тусгаж албан бичгээр хүргүүлж байх зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлэв.

1.1.4. Хяналт-шинжилгээ үнэлгээний тайланд алдаа, зөрчлийг засах зөвлөмж өгч байгаа хэдий ч хэрэгжүүлэх хугацаа, хариуцах эзэн тодорхойгүйгээс хяналт, шинжилгээний үр дүн бүрэн гарахгүй байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн зөвлөмжийн биелэлтийг аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргаа удирдлагын хэлтэс нь аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлээгүй байна.

Аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргаа удирдлагын хэлтэс нь “Баянхонгор аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2021 оны хэрэгжилт, “Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2021 оны хэрэгжилт, аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтэст 30 хоногоор хугацаа хоцорч хүргүүлсэн байна.

“Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн тайланд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн дагуу Ногоон хөгжлийн бодлогын 23 зүйл заалтаас суурь түвшин, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг

³ 5.1.3. хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтээр зөвлөмж өгөх, өгсөн зөвлөмжийг хангалтгүй биелүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг эрх бүхий албан тушаалтанд гаргах;

хэрэгжүүлэх арга хэмжээг уялдуулан, утга агуулгаараа ижил давхацсан зорилтуудыг нэгтгэн 8 арга хэмжээ болгон боловсруулсан байна.

Хүснэгт №4. Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн өөрчлөлт

№	Өмнөх	Шинэчлэгдсэн
1	5.1.3.Хөрсний үржил шим, чийгийг хамгаалж, газрын доройтол, хөрсний бохирдол, цөлжилтөөс сэргийлэн эвдрэлд орсон доройтсон газрыг нөхөн сэргээнэ.	5.1.1. "Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
2	5.1.6.Газрын доройтол, цөлжилтийг сааруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	
3	5.1.8.Орон нутгийн нөөц боломжоор 1 сая тод тарьж, ойн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.	
4	5.1.7.Мэргэжлийн байгууллагаар аймгийн ойн менежментийн төлөвлөгөө боловсруулж батлуулна.	
5	5.1.9.Түйн голын ай савыг бургасжуулж, урсацыг нэмэгдүүлнэ.	
6	5.1.5.Хамгаалах ашиглах зарчмаар нутгийн иргэдийн оролцоонд тулгуурлан байгаль орчныг хамгаална.	5.2.1.Булгийн эхийг хамгаалах, ундаргыг сэргээх, хөв байгуулах ажлыг зохион байгуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
7	5.2.1.Булгийн эхийг хамгаалах, ундаргыг сэргээх, хөв байгуулах ажлыг малчид, малчдын бүлэг, нөхөрлөлийн хамтаар хийж хэрэгжүүлнэ.	5.2.3. Хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангана.
8	5.2.2.Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс,ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулах, усны бохирдол хомсдолыг бууруулж ажиллана	5.2.2. Зэрлэг амьтдыг хамгаалах өвс тэжээлийн хомсдолоос урьдчилан сэргийлэх амьдрах орчныг сайжруулна.
9	5.2.5.Зэрлэг амьтдыг хамгаалах өвс тэжээлийн хомсдолоос урьдчилан сэргийлэх, амьдрах орчныг сайжруулах чиглэлээр зэрлэг амьтны байршил бүхий газруудад биотехникийн арга хэмжээ авна.	
10	5.1.1. Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөнө.	Хасагдсан
11	5.1.2. Цэнгэг усны нөөц, урсац бүрэлдэх эхүүдийг судлаж хамгаалах, урцыг нэмэгдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ	Хасагдсан
12	5.1.4.Иргэдийн 20%-д ногоон хөгжил, тогтвортой хөгжлийн боловсрол олгоно.	Хасагдсан
13	5.2.3.Баацагаан сумын Бөөнцагаан нуурыг улсын тусгай хамгаалалттад авах талаар ажлыг дээд шатны байгууллагад уламжилж, Бөөнцагаан нуурын менежементийн төлөвлөгөөг боловсруулна.	Хасагдсан
14	5.2.4. Газрын байгалийн тогтоц, нуга, голын татамд хур тунадас, хайлсан цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм, Байдраг голыг түшиглэн олон зориулалтаар ашиглах усан сан байгуулна.	Хасагдсан
15	5.2.6.Усны нөөц, гидрогеологийн зураглал хийж, усны нөөц баялгийн мэдээллийн сан бүрдүүлэн усны нөөцөд хэрэглээг хэвшүүлнэ.	Хасагдсан
16	5.2.8.Хүлэмжийн хийн ялгарлыг 10 хувиар бууруулна.	Хасагдсан
17	5.2.9.Ус, цаг уурын ажиглалтын болон орчны хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлж байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулна.	Хасагдсан
18	5.2.10.Хог хаягдлын менежементийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх, хог хаягдлын дахин боловсруулалтын үйлдвэрлэлийг дэмжиж хөгжүүлнэ.	Хасагдсан
19	5.2.11.Орон нутгийн иргэдэд түшиглэсэн уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ төслийг хэрэгжүүлнэ.	Хасагдсан

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргаа удирдлагын хэлтэс нь зорилт арга хэмжээг Монгол улсын Засгийн газрын 2021 оны 119 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 3 дугаар хавсралтад нийцүүлэн дахин боловсруулсан боловч аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулаагүй байна.

Иймд дахин боловсруулсан баримт бичгийг аймгийн ИТХ-аар батлуулах, өгсөн зөвлөмжийн үр нөлөөг гаргах зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлэв.

Аудитын илрүүлэлт

- Аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтэс нь “Баянхонгор аймгийн ногоон хөгжлийн хэтийн зорилт-2028 дунд хугацааны бодлогын баримт бичиг”-ийн хэрэгжилтийг хяналтад аваагүй байна.

Дээрх зөрчилд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ийн 5.1.3 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлэв.

1.2. Үндэсний болон дэд хөтөлбөрүүдэд тусгагдсан зорилт арга хэмжээний хэрэгжилтийг гаргаж дүгнэсэн байна.

1.2.1. Үндэсний болон дэд хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг батлахгүй байна.

Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээтэй холбоотой улсын хэмжээнд дараахь 7 үндэсний хөтөлбөрүүд хэрэгжиж байна. Үүнд:

- Засгийн газрын 2014 оны 341 дүгээр тогтоолоор батлагдсан “Удаан задардаг органик бохирдуулагчийн үндэсний хөтөлбөр
- Улсын их хурлын 2021 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Ус үндэсний хөтөлбөр”
- Засгийн газрын 2014 оны 298 дугаар тогтоолоор батлагдсан “Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр”
- Засгийн газрын 2005 оны 44 дүгээр тогтоолоор батлагдсан “Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөр
- Засгийн газрын 2015 оны 325 дугаар тогтоолоор батлагдсан “Биологийн олон янз байдлын тухай” үндэсний хөтөлбөр
- Засгийн газрын 2011 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр:
- Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор батлагдсан “Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”

Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор батлагдсан “Агаар орны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд “Агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах” дэд хөтөлбөрийг 2017-2020 онд хэрэгжүүлэхээр аймгийн ИТХ-ын 2017 оны 146 дугаар тогтоолоор баталсан байна.

Хүснэгт №05. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгийн судалгаа /сая төг/

д/д	Үндэсний хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	2020		2021			
			Улсын төсөв	БХНСАХЗ	Улсын төсөв	ОНХС	БХНСАХЗ	Төсөл хөтөлбөр
1	Ус үндэсний хөтөлбөр	2016-2021		43.0			32.0	
2	Хог хаягдлын менежментийн	2014-2022	50.0	90.0		439.0	40.0	

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ОРЛОГОД БАЙГАЛЬ ОРЧНООС ОРЖ ИРЖ
БАЙГАА ХӨРӨНГӨ ТӨВЛӨРҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ ҮР ДҮН /2020-2021/**

д/д	Үндэсний хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	2020		2021			
			Улсын төсөв	БХНСАХЗ	Улсын төсөв	ОНХС	БХНСАХЗ	Төсөл хөтөлбөр
	сайжруулах үндэсний хөтөлбөр							
3	Ногоон хэрэм үндэсний хөтөлбөр	2005-2015 2015-2025 2025-2035						
4	Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр	2020-2022	-	-	-	-	-	
5	"Биологийн олон янз байдлын тухай" үндэсний хөтөлбөр	2021-2025	-	-	-	-	-	
6	Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр	2011-2016 2017-2021						
7	Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр	2017-2019 2020-2025	345.6	50.0	4,000.0	38.0		1,875.0
	Нийт дүн		395.6	50.0	4,000.0	477.0	72.0	1,875.0

Эх үүсвэр: Хөтөлбөрүүдийн тайлангаас

1.2.2 Дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт, Үндэсний болон дэд хөтөлбөрүүдийн уялдаа хангагдсан байна.

Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн байгаль орчин, ногоон хөгжлийн бодлоготой холбоотой заалтуудыг үндэсний хөтөлбөрүүдтэй дараахь байдлаар уялдуулан төлөвлөсөн байна.

Хүснэгт №06. Дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт, үндэсний болон дэд хөтөлбөрүүдийн уялдаа

д/д	Үндэсний хөтөлбөр	Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан заалт	Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
1	Ус үндэсний хөтөлбөр	4	7
2	Хог хаягдлын менежментийн үндэсний хөтөлбөр	1	2
3	Ногоон хэрэм үндэсний хөтөлбөр	2	7
4	Нэн ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр	1	1
5	Биологийн олон янз байдлын тухай үндэсний хөтөлбөр	1	1
6	Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр	1	1
7	Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр	1	2
	Нийт дүн	11	21

1.2.3. Үндэсний болон дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг гаргаж дүгнэж холбогдох байгууллагад хүргүүлж байгаа боловч үнэлгээ бодитой биш байна.

Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг БОАЖГ нь Засгийн газрын 89 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтын дагуу бэлтгэж аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-т ирүүлснийг жил бүрийн 2 дугаар сарын 10-ны дотор холбогдох яамдад хүргүүлсэн байна.

Хүснэгт №07. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт

№	Хөтөлбөрийн нэр	2020		
		Хэрэгжилтийн хувь	Зарцуулсан мөнгөн дүн (Сая, төгрөг)	Эх үүсвэр
1	Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр	82.0	10.0	БОНСАХ
	Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр	88.0	153.7	Орон нутгийн хөгжлийн сан
2			528.8	НҮБ-ын “Орон нутгийн иргэдэд түшиглэсэн, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй Ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ” төсөл
			16.0	БОНСАХ
			250.0	НҮБ-ын Утаагүй Баянхонгор төсөл
3	Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай үндэсний хөтөлбөр	80.0	-	-
4	Ус үндэсний хөтөлбөр	100.0	132.0	Орон нутгийн төсөв
5	Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр	77.5	172.0	Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтийг хангах нь төсөл
6	Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр	92.0	90.0	Улсын төсөв
7	Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр	80.0	40.0	БОНСАХ
8	Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	92.0	-	-

Харин аймгийн ИТХ-аас 2017-2021 онд баталсан дэд хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн талаар талаарх танилцуулгыг аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн даргын 2022.04.15 өдрийн 3/730 тоот албан бичгээр аймгийн ИТХ-ын даргад хүргүүлсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргаа удирдлагын хэлтсээс хийсэн “Агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах” дэд хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнгийн талаарх танилцуулгад агаар, хөрс, усны бохирдол хэдэн хувиар буурсан нь тодорхой биш, тус хөтөлбөр үр дүнтэй хэрэгжсэн эсэх талаар үнэлгээ дүгнэлт хийгээгүй байна.

Аймгийн БОАЖГ “Агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах” дэд хөтөлбөрийн 2020 оны хэрэгжилтийг 87.5 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

1.2.4. Үндэсний болон дэд хөтөлбөрүүдийн 2021 оны тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт, шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна.

Аймгийн ЗДТГ-ын ХШҮХ “Агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах” дэд хөтөлбөрийн 2020 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж 92.5 хувь, 2021 оны хэрэгжилтэд хяналт шинжилгээ-үнэлгээ хийгээгүй байгаа нь Засгийн газрын 2020 оны 206 дугаар тушаалаар “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5⁴ дахь заалтыг зөрчсөн байна.

1.2.5. Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг дүгнээд хэрэгжээгүй болон дутуу хэрэгжсэн ажлуудыг сайжруулах чиглэлээр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн ЗДТГ-ын ХШҮХ нь Улсын их хурал, Засгийн газрын тогтоол шийдвэрээр баталсан байгаль орчны салбарын үндэсний 4 хөтөлбөрийн 2020 оны хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж 2 нийтлэг зөвлөмжийг аймгийн Засаг даргад өгсөн боловч түүнийг хэрэгжилтийг эргэн тооцоогүй байна.

Энэ талаар аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ийн даргаас тодруулахад “Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд өмнөх онуудад ХШҮ хийж байгаагүй одооноос жигдрүүлж, анаарч ажиллаж байгаа” гэсэн тайлбарыг өгсөн болно.

БҮЛЭГ 2. АЖИЛ ХАРИУЦСАН БАЙГУУЛЛАГУУД ХУУЛИАР ТОГТООСОН ЧИГ ҮҮРГЭЭ БҮРЭН БИЕЛҮҮЛЭЭГҮЙГЭЭС УС РАШААН АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ОРЛОГО БҮРЭН ТӨВЛӨРӨХГҮЙ ӨМНӨХ АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ ДАВТАГДАЖ БАЙНА.

2.1. Ан, амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогыг журмын дагуу валютын ханшаар зөв тооцоогүйгээс төсөвт дутуу төвлөрүүлсэн, Шонхорын өгөөшний орлогыг тооцож аваагүй байна.

2.1.1. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас олгосон зөвшөөрлийн дагуу иргэн аж ахуйн нэгжид шонхор шувуу бариулах гэрээг сумдын Засаг дарга нар байгуулсан байна.

Засгийн газрын 2019 оны “Тусгай зориулалтаар 2020 онд агнах, барих агнуурын тоо хэмжээг тогтоох тухай” 439 дүгээр тогтоолыг үндэслэн Байгаль орчин аялал

⁴ Энэ журмын 3.2.1-д заасан бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний явцын болон эцсийн тайланг мөн журмын 2-3 дугаар хавсралтын дагуу гаргаж, журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлнэ.

жуулчлалын сайдын 2019 оны А/8177 тушаалаар 2020 онд Баянхонгор аймгийн 6 сумд 9 угалз, 7 сумд 16 тэх, 1 сумд 2 буга агнуулах зөвшөөрөл олгосон байна.

Тусгай зориулалтаар агнах ангийн хуваарь батлагдсан боловч 2020 онд Ковид-19 цар тахал өвчлөл, 2021 онд ган зудын байдлаас шалтгаалан тусгай зориулалтын ан агнуурын үйл ажиллагааг 2 жилийн хугацаанд зохион байгуулаагүй байна.

Харин Баянцагаан сумын Баянцагаан агнуурын бүс нутагт 2020 онд тусгай зориулалтаар агнуулахаар 2 толгой угалз, 2 толгой тэх ангийн зөвшөөрөл хуваарилагдсан бөгөөд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого болох 21.9 сая төгрөгийг тус сумын төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн боловч тухайн ан агнуур хийгдээгүй байхад тус орлогыг зарцуулсан байна.

БОАЖЯ-ны албан тоот бичгээр аймгуудын нэр заасан бүс нутгаас шонхор барих зөвшөөрлийг олгосны дагуу гадаадын иргэнтэй шонхор бариулах гэрээ байгуулсан байна.

Хүснэгт №08. Баянхонгор аймгийн 2020-2021 онд барьсан шонхрын тооцоо

д.д	Сумын нэрс	Шонхорын тооцоо					
		Барьсан тоо, толгой		Сумдаас ирүүлсэн идлэг шонхор шувуу барьсан актын тоо		Ирүүлээгүй материалын тоо	
		2020	2021	2020	2021	2020	2021
1	Эрдэнэцогт	4	4	4	4	0	0
2	Баян-Овоо	4	3	3	3	1	0
3	Баянбулаг	2	1	0	1	2	0
4	Гурванбулаг	10	4	10	4	0	0
5	Жаргалант	3	6	0	6	3	0
6	Баянхонгор		6		6	0	0
7	Өлзийт		14		14	0	0
8	Богд		2			0	2
9	Заг		8		5	0	3
10	Галуут		4			0	4
11	Хүрээмарал		1			0	1
	Дүн	23	53	17	43	6	10

Эх сурвалж: БОАЖГ болон сумдаас ирүүлсэн гэрээ, акт

Идлэг шонхор шувууг соёлын зориулалтаар дээрх сумдаас 2020 онд 23 тоо толгой, 2021 онд 53 тоо толгойг бариулсан байна.

Аудитаар аудитад шаардлагатай баримт материал ирүүлэхийг БОАЖГ болон сумдын ЗДТГ-аас шаардсан боловч 2020 онд Баян-Овоо, Баянбулаг, Жаргалант сумд нийт 6, 2021 онд Богд, Заг, Галуут, Хүрээмарал сумд нийт 10 гэрээ, актыг ирүүлээгүй нь Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1⁵ дэх заалтыг зөрчиж байна.

Иймд тусгай зөвшөөрлөөр идлэг шонхор шувуу бариулах гэрээ, актыг хүлээн авч хяналт тавиагүй холбогдох буруутай албан хаагч нарт хариуцлага тооцуулах албан

⁵ шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг хэлбэрээс нь үл хамааран шалгагдагч этгээд, аудитад хамрагдагч болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтнаас тогтоосон хугацаанд, үнэ төлбөргүйгээр гаргуулах, хуулбарлаж авах;

шаардлагыг холбогдох томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.1.2. Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь идлэг шонхор шувуу бариулах зөвшөөрөл олгохдоо Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 2 өөр заалтыг үндэслэн нэг идлэг шонхрын үнэлгээг 2020, 2021 онд ялгаатай тогтоосон байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь 2020 онд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2⁶ дахь заалтын дагуу идлэг шонхор шувууг соёлын зориулалтаар барих төлбөр хураамжийг бариулсан шонхор тутамд 6.4 сая төгрөгөөр тогтоосон.

Харин 2021 онд тус хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.6⁷ дахь заалтын дагуу нэг идлэг шонхор тутамд гадаад зах зээлийн жишиг үнийн 80 хувиар буюу 9600 ам доллароор тооцож идлэг шонхор шувуу бариулах зөвшөөрөл олгосон байна.

Дээрх нөхцөл байдлаас үзэхэд 2020 онд нэг идлэг шонхор тутмаас 20.8 сая /нийт 478.4 сая/ төгрөг олох боломжийг алдсан байна.

2.1.3. Идлэг шонхор шувуу барихад өгөөш болгон ашиглах шувууны төлбөр хураамжийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй байна.

Баянхонгор аймгийн хэмжээнд 2020 онд 23, 2021 онд 43 шонхор шувуу тусгай зөвшөөрлөөр бариулж 2020 онд 147.2 сая, 2021 онд 1,447.0 сая төгрөг төвлөрүүлсэн ба шонхор шувуу бариулсан тухайн өдрийн Монгол банкны ханшаар тооцож үзэхэд 2.0 сая төгрөг дутуу төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №09. Шонхор шувууны орлогын судалгаа

№	Сумын нэр	Барьсан тоо толгой	Төлбөл зохих /сая төг/	Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн	Зөрүү
1	Эрдэнэцогт	4	25.6	25.6	0
2	Баян-Овоо	4	25.6	25.6	0
3	Баянбулаг	2	12.8	12.8	0
4	Гурванбулаг	10	64.0	64.0	0
5	Жаргалант	3	19.2	19.2	0
	2020 оны нийт дүн	23	147.2	147.2	-
1	Баянхонгор	6	164.1	163.8	0.3
2	Өлзийт	14	382.9	382.2	0.7
3	Богд	0	54.6	54.6	-
4	Гурванбулаг	4	109.4	109.2	0.2
5	Заг	5	218.6	218.4	0.2
6	Жаргалант	6	164.1	163.8	0.3
7	Галуут	0	109.2	109.2	-

⁶ ахуйн, үйлдвэрлэл, соёл, шинжлэх ухааны зориулалтаар агнасан бусад ан амьтны төлбөрийг тухайн ан амьтны толгой тутмын экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40 хувиар;

⁷ амьдаар нь гадаад оронд гаргасан ан амьтны төлбөрийг гадаад зах зээлийн тухайн үеийн үнэ буюу эрх бүхий байгууллагаас тогтоосон жишиг үнийн 80-90 хувиар.

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ОРЛОГОД БАЙГАЛЬ ОРЧНООС ОРЖ ИРЖ
БАЙГАА ХӨРӨНГӨ ТӨВЛӨРҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ ҮР ДҮН /2020-2021/**

№	Сумын нэр	Барьсан тоо толгой	Төлбөл зохих /сая төг/	Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн	Зөрүү
8	Эрдэнэцогт	4	109.4	109.2	0.2
9	Баян-Овоо	3	82.0	81.9	0.1
10	Баянбулаг	1	27.3	27.3	0.0
11	Хүрээмарал	0	27.3	27.3	-
	2021 оны нийт дүн	43	1,449.0	1,447.0	2.0

Мөн өгөөш болгон ашиглах шувууны төлбөр хураамжийг Засгийн газрын “Төлбөр хураамжийг шинэчлэн батлах тухай” 2017 оны 339 дүгээр тогтоолын 2 дугаар хэсгийн 22-т заасны дагуу орон нутгийн дансанд тушаахаар заасан байхад хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал: Баянхонгор аймгийн хэмжээнд 2020-2021 онд 70 шонхор шувуу бариулахад ашиглах өгөөшний үнэлгээг тухайн өдрийн Монгол банкны ханшаар тооцоход 4.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй байна.

Хүснэгт №10. Шонхор шувууны өгөөшний тооцоо

д/д	Сумын нэр	Барьсан тоо, толгой		Нэг шувууны өгөөшийн үнэлгээ /20 ам дол/	Төлбөрийн дүн /сая.төг/
		2020	2021		
1	Эрдэнэцогт	4	4	160	0.5
2	Баян-Овоо	4	3	140	0.4
3	Баянбулаг	2	1	60	0.2
4	Гурванбулаг	10	4	280	0.8
5	Жаргалант	3	6	60	0.5
6	Баянхонгор		6	120	0.3
7	Өлзийт		14	280	0.8
8	Богд		2	40	0.1
9	Заг		8	160	0.3
11	Галуут		4	80	0.2
12	Хүрээмарал		1	20	0.1
	Дүн	23	53	1400	4.2

Цаашид шонхор шувуу барихад өгөөшөөр ашигласан шувууны төлбөрийн орлогыг тухай бүрд нь тооцож бүрэн төвлөрүүлэх зөвлөмжийг сумдын Засаг дарга нарт хүргүүлэв.

2.2. Ан, амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг хуульд заасан хэмжээгээр төлөвлөхгүй байна.

2.2.1. Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд хуульд нийцүүлэн төлөвлөөгүй байна.

Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоос Байгалийн нөөц ашигласны ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1⁸ дэх хэсэгт заасны дагуу байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 2020 онд 73.6 сая, 2021 онд 723.5 сая төгрөг төлөвлөхөөр байхад 2020 онд төлөвлөөгүй, 2021 онд 87.6 сая төгрөг төлөвлөсөн байна.

Хүснэгт №11. Байгалийн нөөц ашигласны ашигласны төлбөрийн орлогын хуваарилалт /сая.төг/

№	Сумын нэр	Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд төлөвлөвөл зохих	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд төлөвлөсөн	зөрүү
1	Эрдэнэцогт	25.6	12.8		12.8
2	Баян-Овоо	25.6	12.8		12.8
3	Баянбулаг	12.8	6.4		6.4
4	Гурванбулаг	64.0	32		32
5	Жаргалант	19.2	9.6		9.6
2020 оны нийт дүн		147.2	73.6	0.0	73.6
1	Баянхонгор	163.8	81.9		81.9
2	Өлзийт	382.2	191.1	73.6	117.5
3	Богд	54.6	27.3		27.3
4	Гурванбулаг	109.2	54.6	6.0	48.6
5	Заг	218.4	109.2	8.0	101.2
6	Жаргалант	163.8	81.9		81.9
7	Галуут	109.2	54.6		54.6
8	Эрдэнэцогт	109.2	54.6		54.6
9	Баян-Овоо	81.9	41.0		41.0
10	Баянбулаг	27.3	13.7		13.7
11	Хүрээмарал	27.3	13.7		13.7
2021 оны нийт дүн		1,447.0	723.5	87.6	635.9

Гурванбулаг сум 2020 онд төвлөрсөн орлогоос 2021 онд 6.0 сая, Заг сум 2021 онд төвлөрсөн орлогоос төсвийн тодотголоор 8.0 сая, Өлзийт сум 2021 онд төвлөрсөн орлогоос төсвийн тодотголоор 73.6 сая төгрөгийн орлогыг байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд төлөвлөсөн байна.

Иймд ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд Байгалийн нөөц ашигласны ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр төлөвлөж сумын ИТХ-аар батлуулж байх зөвлөмжийг сумдын Засаг дарга нарт хүргүүлэв.

2.2.2. Ан, амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогыг бодит бус хэмжээнд төлөвлөснөөс ихэнх орлого төвсийн зардалд зарцуулж байна.

Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоос 2020 онд 73.6 сая төгрөгийг төсвийн дутагдсан эх үүсвэрийг нөхөж урсгалд зардалд зориулалт бусаар зарцуулсан байна. Харин 2021 онд 87.6 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 23.4 сая төгрөг зарцуулсан байна.

⁸ Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно:

Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам” батлагдсан бөгөөд тус журмын 3.4⁹ дэх заалтаар амьтны нөөц ашигласны төлбөрийн зардлын нэр төрлийг заасан байна.

Хүснэгт №12. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын зарцуулалт /сая.төг/

д/д	Сумын нэр	2021 онд зарцуулсан дүн	Хог хаягдал зайлуулах, нохой устгах	Амьтанд өвс тэжээл тавьж өгөх	Дроны батериа станц авахад	Шатахууны зардал
1	Гурванбулаг	5.9	4.1	0.09	1.7	
2	Заг	6.8	6.8			
3	Өлзийт	10.7	1	5.8		3.9
	Дүн	23.4	11.9	5.89	1.7	3.9

Дээрх хүснэгтээс харахад 2021 онд 23.4 сая төгрөгийг байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний батлагдсан зардлаас зарцуулсан бөгөөд үүний 11.5 сая төгрөгийг амьтанд өвс тэжээл тавьж өгөх 5.6 сая төгрөгийг амьтан хамгаалах зардалд зориулалтын дагуу зарцуулсан байна.

2.3. Ус, рашаан ашигласны төлбөрийн орлогыг бодитой төлөвлөөгүй, ус ашиглагчийн ус ашиглах үйл ажиллагаанд тавих мэргэжлийн эрх бүхий байгууллагууд хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс ус, рашаан ашигласны төлбөрийн орлогыг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлээгүй байна.

2.3.1. Ус, рашаан ашигласны төлбөрийн орлогыг өмнөх жилүүдийн татварын орлогын гүйцэтгэлд үндэслэн бодит бус төлөвлөж байна.

Ус, рашаан ашигласны төлбөрийн орлогыг аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс өмнөх онуудын татварын орлогын гүйцэтгэлд тулгуурлан төлөвлөсөн байна.

Хүснэгт №13. Ус, рашаан ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл /сая.төг/

Орлогын төрөл	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он
	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Ус, рашаан ашигласны төлбөр	438.9	264.6	334.1	450.0	584.7
				500.0	467.2

Төлөвлөлтийг хэрхэн тооцож талаар холбогдох мэргэжилтнээс тодруулахад:

“Ус рашаан ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөх үед хэдэн аж ахуйн нэгж ус ашиглах нь тодорхойгүй, Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргаанаас ирүүлсэн ус ашиглагчийн судалгаа нь төлөвлөж буй он бус тухайн тайлант онд ус

⁹ 3.4. Амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийг энэхүү журмын 2.2.2-т заасныг үндэслэн тухайн суманд:

3.4.1. аймгийн болон агнуурын бүс нутгийн ан, агнуурын менежментийн төлөвлөгөө боловсруулах, сайжруулах, хэрэгжүүлэх, сурталчлах, нутгийн иргэдэд түшиглэсэн агнуурын менежментийг хэрэгжүүлэх;

3.4.2. амьтны амьдрах орчинг нөхөн сэргээх, тэтгэх, агнуурын амьтны судалгаа, мониторинг хийх;

3.4.3. Амьтны тухай хуулийг хэрэгжүүлэх нөхцлийг хангах сургалт, сурталчилгаа, хяналт шалгалт хийх арга хэмжээнд тус тус зарцуулна.

ашиглаж байгаа ус ашиглагчийн судалгааг ирүүлдэг. Мөн тус газрын гаргасан судалгаагаар тоолуурын заалтаар, эсхүл ажилласан хоногоор ногдуулалт хийж гэрээг дүгнэж төлбөрийг тооцсон байдаг нь дүгнэлтээр авах усны төлбөрөөс бага байдаг тул ус, рашаан ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөхдөө өмнөх онуудын татварын орлогын гүйцэтгэлд тулгуурлан дунджаар төлөвлөж байгаа” гэсэн тайлбарыг өгөв.

Иймд ус, рашаан ашигласны төлбөрийн орлоготой холбоотой зөвшөөрөл, гэрээ, төлбөрийн тайлан мэдээг гаргасан дүгнэлттэй харьцуулан үнэн зөв тайлагнасан эсэхийг нягтлан үзэж, төлбөрийн орлогыг бодитой төлөвлөж буй эсэхэд хяналт тавьж ажиллах зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-т хүргүүлэв.

2.3.2. Ус ашиглагчийн ус ашиглах үйл ажиллагаанд тавих мэргэжлийн эрх бүхий байгууллагууд хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс орон нутгийн төсөвт 106.4 сая төгрөгийн ус, рашаан ашигласны төлбөрийн орлогыг төвлөрүүлэх боломжийг алдсан байна.

Усны тухай хуулийн дагуу хоногийн хэрэгцээ 50 м³-ээс доош ус ашиглагчийн ус ашиглах дүгнэлтийг аймгийн БОАЖГ гаргаж, ус ашиглах гэрээг сумдын Засаг дарга, хоногийн хэрэгцээ нь 50м³-100 м³ ус ашиглах дүгнэлтийг Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргаа гаргаж, ус ашиглах зөвшөөрөл, ус ашиглах гэрээг БОАЖГ, хоногийн хэрэгцээ нь 100м³ –ээс дээш ус ашиглах дүгнэлтийг 2020 онд “Монгол-Ус” ТӨААТҮГ, 2021 оноос Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар гаргаж, ус ашиглах зөвшөөрөл ус ашиглах гэрээг Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргаа байгуулан ажилласан байна.

Аудитад хамрагдсан 2020-2021 онуудад “Монгол-Ус” ТӨААТҮГ, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар нь Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулдаг 12 аж ахуйн нэгжид давхардсан тоогоор нийт 20 ус ашиглуулах дүгнэлт гаргаснаас Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргаа нь 2020 онд Баянхонгор суманд төвлөрсөн усан хангамжийн үйл ажиллагаа явуулдаг “Чандмань-Баянхонгор” ХК-д ус ашиглах зөвшөөрөл олгож гэрээ байгуулаагүй, “Монгол-Ус” ТӨААТҮГ-аас 2020 онд ус ашиглуулах дүгнэлт гаргасан “Мөнхийн номхон далай” ХХК нь ус ашиглах зөвшөөрөл авч гэрээ байгуулаагүй, үйл ажиллагаа явуулаагүй байна.

Хүснэгт №14. Ус ашиглуулах дүгнэлт, гэрээний судалгаа

Байгууллагын нэр	2020 ОН				2021 ОН			
	Дүгнэлт гаргасан		Үүнээс гэрээ байгуулсан		Дүгнэлт гаргасан		Үүнээс гэрээ байгуулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
“Монгол-Ус” ТӨААТҮГ	9	735.6	8	621.1				
Усны газар					10	815.7	11	853.9
Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргаа	3	58.0	2	56.6	2	51.1	2	51.1

Харин Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргаа нь Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулдаг ус, рашаан ашиглагч 3 аж ахуйн нэгжид ус ашиглуулах дүгнэлт гаргаж БОАЖГ, Баянхонгор, Өлзийт сумдын Засаг дарга ус ашиглуулах зөвшөөрөл олгож гэрээ байгуулсан байна.

Ус, рашаан ашиглагч нь Усны тухай хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагаас ус ашиглуулах дүгнэлт гаргуулаагүй байхад гэрээ байгуулж ус ашиглуулсан, ус ашиглуулах дүгнэлт гаргуулж гэрээ байгуулаагүйгээр ус, рашаан ашиглаж байхад түүнд хяналт тавиагүй байна. Тухайлбал:

Аудитын илрүүлэлт:

1. Бөмбөгөр сумын нутагт ус ашиглаж уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг “Хишигт хөндий” ХХК нь 2021 онд ус ашиглах дүгнэлт гаргуулаагүй ба “Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргаа”-тай 2021.04.06-ны өдөр 02 тоот “Ус ашиглах гэрээ”-г “Монгол-Ус” ТӨААТҮГ-ын 2020.04.03-ны өдрийн 1/24 дугаартай ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн байгуулж үйл ажиллагаа явуулсан байна. Гэсэн хэдий ч Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргаа болон “Хишигт хөндий” ХХК-нд тус 2020 оны 1/24 дугаартай ус ашиглуулах дүгнэлт нь байхгүй бөгөөд энэ талаар Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргааны дарга нь 2022.10.05-ы өдрийн 115 тоот албан бичгээр тайлбар ирүүлэхдээ “Манай байгууллагаас 2020, 2021 онуудад “Хишигт хөндий” ХХК-д ус ашиглуулах зөвшөөрөл олгож, гэрээ байгуулсан харилцаа үүсээгүй учир тус гэрээнд гарын үсэг зурсан албан тушаалтнуудаас мэдүүлэг авах нь зүйтэй” гэжээ. Тус компани нь 2021 онд тоолуурын заалтаар 9033 м3 ус ашиглаж 8.5 сая төгрөгийн ус ашигласны төлбөр төлсөн байна.

Энэ нь Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.10¹⁰, 19 дүгээр зүйлийн 19.1.1¹¹, 28 дугаар зүйлийн 28.18¹² дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд тус аж ахуйн нэгжийн ус ашиглуулах зөвшөөрөлтэй холбоотой асуудлыг шалгаж шийдвэрлэх албан бичгийг аймгийн Мэргэжлийн хяналтын газарт хүргүүлэхээр шийдвэрлэв.

2. Бөмбөгөр сумын нутагт ус ашиглаж уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг “Ай Эн Ди” ХХК нь ус ашиглах дүгнэлт гаргуулаагүй, ус ашиглах зөвшөөрөл авч гэрээ байгуулаагүй 2021 онд ус ашиглан 2 сар үйл ажиллагаа явуулсан байхад холбогдох эрх бүхий байгууллагууд үйл ажиллагааг зогсоогоогүй, Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргаа нь ашигласан усанд ногдуулалт хийж төлбөр тогтоогоогүй байна. Харин аймгийн Санхүүгийн хяналт аудитын албанаас тус компанийн 2021.07.08-2021.08.08-ны хүртэл 30 хоногийн хугацаанд ашигласан усанд ногдуулалт хийж 7.2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож төлүүлсэн байна.

Энэ нь Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.10, 19 дүгээр зүйлийн 19.1.1, 28 дугаар зүйлийн 28.18 дэх заалтыг тус тус зөрчсөн тус үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий байгууллагуудын ажлын хариуцлагагүй байдлыг харуулж байна.

Иймд тус аж ахуйн нэгжийн 2021 онд ажилласан хугацааг тогтоож, ажилласан хугацаанд ногдох ус ашигласны төлбөрийг тогтоон нөхөн төлүүлэх албан шаардлагыг Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргаанд хүргүүлэв.

3. Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутагт рашаан сувиллын үйл ажиллагаа явуулдаг “Амар амгалан Шаргалжуут” ХХК нь 2021 онд ус, рашаан ашиглах дүгнэлт гаргуулаагүй, ус ашиглах зөвшөөрөл авч гэрээ байгуулаагүй үйл ажиллагаа явуулсан байхад холбогдох эрх бүхий байгууллагууд үйл ажиллагааг зогсоогоогүй, Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргаа нь ашигласан рашаан, усанд ногдуулалт хийж төлбөр тогтоогоогүй байна.

¹⁰ сав газрын хэмжээнд ашиглах боломжит усны нөөц, ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавьж ажиллах;

¹¹ хариуцсан нутаг дэвсгэртээ усны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгах арга хэмжээ авах;

¹² Ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглах, дур мэдэн цооног гаргахыг хориглоно;

Иймд тус аж ахуйн нэгжийн 2021 онд ажилласан хугацааг тогтоож, ажилласан хугацаанд ногдох ус ашигласны төлбөрийг тогтоон нөхөн төлүүлэх албан шаардлагыг Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргаанд хүргүүлэв.

Ус ашиглагч аж ахуйн нэгжүүдэд ус ашиглах зөвшөөрөл олгож ус ашиглуулах гэрээ байгуулж байгаа Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргаа, БОАЖГ нь зарим аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан гэрээг дүгнээгүй, зарим аж ахуйн нэгжүүдийн ашигласан усны хэмжээг тоолуурын заалт болон ажилласан хүчин чадал, хоногт нь ногдуулалт хийгээгүйгээс орон нутгийн төсөвт 106.4 сая төгрөгийн ус, рашаан ашигласны төлбөрийн орлогыг төвлөрүүлэх боломжийг алдсан байна.

Хүснэгт №15. Ус рашаан ашигласны төлбөрийн ногдуулалт

Аж ахуйн нэгжийн нэр	Дүгнэлтээр төлөх		Аудитаар гүйцэтгэлд суурилсан төлбөл зохих		Төлсөн		Дутуу		
	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021	Нийт
"Шаргалжуут рашаан сувилал" ХХК	55.2	48.3	87.5	53.2	41.4	10.0	46.0	43.2	89.3
"Баян-Ундрага Зэндмэнь" ХХК	1.4	2.8	6.9	6.3	1.4	2.8	5.5	3.5	9.1
"Амар амгалан Шаргалжуут" ХХК	1.4	-	2.9	3.6	1.4	-	1.5	3.6	5.1
"Чандмань Баянхонгор" ХХК	-	6.8	5.3	12.1	7.5	6.8	(2.2)	5.2	3.0
НИЙТ ДҮН	58.0	57.9	102.5	75.2	51.7	19.6	50.8	55.6	106.4

Аудитын илрүүлэлт:

Баянхонгор аймагт рашаан сувиллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 3 аж ахуйн нэгжид Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргаа нь ус ашиглуулах дүгнэлт гаргаж 2020 онд Баянхонгор, Өлзийт сумын Засаг дарга, 2021 онд Байгаль орчин аялал жуулчлалын газар ус ашиглуулах зөвшөөрөл олгож гэрээ байгуулсан ч ажилласан хоног, амарсан хүний тоо, ашигласан рашаан, усны хэмжээг тооцож ногдуулалт хийгээгүй бөгөөд аудитаар тус рашаан сувиллуудын 2020, 2021 оны амрагчдын бүртгэлээр ашигласан халуун, хүйтэн рашаанд ногдох төлбөр, ашиг олох зориулалтаар, халаалтын зориулалтаар ашигласан усанд ногдох төлбөрийг Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргааны дүгнэлтээр тооцоход тус 3 рашаан сувилалтай холбоотой нийт 103.5 сая төгрөгийг дутуу тооцож, төсөвт төвлөрүүлэх боломжийг алдсан байна.

Баянхонгор суманд төвлөрсөн усан хангамжийн үйлчилгээ үзүүлдэг "Чандмань Баянхонгор" ХК нь 2020 онд Байгаль орчин, аялал, жуулчлалын яамны газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын газраар усны дүгнэлт гаргуулсан ч ус ашиглах зөвшөөрөл олгож гэрээ байгуулаагүй, 2021 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраар ус ашиглах дүгнэлт гаргуулж Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргаатай ус ашиглах гэрээ байгуулсан ч тус онуудын гэрээг дүгнэж ногдуулалт хийгээгүй байна. Аудитаар тус компанийн ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгжүүдэд борлуулсан усыг Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолоор баталсан усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээгээр тооцож үзэхэд нийт 3.0 сая төгрөгийг дутуу тооцож, төсөвт төвлөрүүлэх боломжийг алдсан байна.

Иймд Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.8-д заасны дагуу сав газрын хэмжээнд ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавих үүргээ хэрэгжүүлж, ус ашиглагчидтай хийсэн гэрээг дүгнэж ажиллах зөвлөмжийг Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргаанд, Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргаа, БОАЖГ ус, рашаан ашиглагч аж ахуйн нэгжүүдтэй хийсэн гэрээг дүгнэж, ногдуулалтыг үнэ зөв хийж байгаад хяналт тавьж, төсөвт төвлөрөх усны төлбөрийг бүрэн төвлөрүүлж ажиллах зөвлөмжийг аймгийн Татварын хэлтэст хүргүүлэв.

Дээрх нөхцөл байдлаас харахад ус ашиглагчийн ус ашиглах үйл ажиллагаанд тавих мэргэжлийн эрх бүхий байгууллагуудын хяналт сул, мэдээлэл нээлттэй бус байгаагаас ус, рашаан ашиглагчтай гэрээ хийгээгүй, усны тайланг бүрэн гаргаагүй, зөвшөөрөлгүй ус ашигласан, төлбөрийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүй зөрчлүүд илэрч байна.

Иймд эрх бүхий байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулан, мэдээллийн ил тод байдлыг хангуулж, хяналтын мөрөөр илэрсэн зөрчил, түүнийг шийдвэрлэсэн байдалд хяналт тавьж ажиллах зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-т хүргүүлэв.

2.3.3. Ус, рашаан ашиглагч зарим аж ахуйн нэгж нь тайлант хугацаанд ногдуулсан төлбөрийг хугацаанд нь бүрэн төвлөрүүлээгүй байна.

Ус, рашаан ашиглагч аж ахуйн нэгжүүдээс 2020-2021 онд нийт 1,051.9 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Үүнээс 199.7 сая төгрөг нь ус ашиглагч аж ахуйн нэгжүүдийн өмнөх оны үлдэгдэл төлбөр байгаа бол 852.2 сая төгрөг нь аудитад хамрагдсан онуудад ус, рашаан ашигласан аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацааны төлбөрийн орлого байна.

Хүснэгт №16. Ус рашаан ашигласны төлбөрийн ногдуулалт төлөлт

Он	Дүгнэлтээр	Ногдуулалтаар төлбөл зохих	Төлсөн
2020 он	793.6	516.9	433.9
2021 он	923.4	476.7	418.3
Нийт	1,717.0	993.6	852.2

Ус, рашаан ашиглах дүгнэлтийг 2020-2021 онд 15 аж ахуйн нэгжид нийт 1,717.0 сая төгрөгийн ус ашиглуулах дүгнэлт гаргаснаас зарим аж ахуйн нэгжүүд нь гэрээ байгуулж үйл ажиллагаа явуулаагүй, тоолуурын заалтаар болон ажилласан хоног ашигласан ус, рашааны хэмжээгээр ногдуулалт хийж тооцсон зэргээс төвлөрүүлбэл зохих орлого 993.6 сая төгрөг болж 723.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №17. Ус рашаан ашигласны төлбөрийн ногдуулалт төлөлт /сая.төг/

Ус ашиглагч ААН-ийн нэр	Нийт төлбөл зохих төлбөр	Төлсөн	Дутуу	Тайлбар
"Шаргалжуут рашаан сувилал" ХХК	140.7	51.4	89.3	Аудитаар нэмж тооцсон
"Баян-Ундрага Зэндмэнь" ХХК	13.2	4.1	9.1	Аудитаар нэмж тооцсон
"Амар амгалан Шаргалжуут" ХХК	6.5	1.4	5.1	Аудитаар нэмж тооцсон
"Чандмань Баянхонгор" ХХК	17.3	14.4	3.0	Аудитаар нэмж тооцсон
Аудитаар давтан тооцооллоор нэмэгдсэн дүн	177.7	71.3	106.5	
"Топ ган дриллинг" ХХК	177.0	166.6	10.4	2022 онд төлж барагдуулсан
"Ар Эс И" ХХК	215.3	213.9	1.4	2022 онд төлж барагдуулсан
"Шижир ранжин" ХХК	39.1	19.3	19.8	2022 онд төлж барагдуулсан
Үлдэгдлийг 2022 онд төлсөн дүн	431.4	399.8	31.6	
"МОНГОЛ БОЛГАР ГЕО" ХХК	51.2	47.6	3.6	Төлөөгүй
НИЙТ ДҮН	660.4	518.8	141.6	

Ус, рашаан ашигласны төлбөрийн орлогыг 8 аж ахуйн нэгж 141.6 сая төгрөгөөр дутуу төлсөн байгаагаас рашаан сувиллын үйл ажиллагаа явуулдаг 3 аж ахуйн нэгж болон төвлөрсөн усан хангамжийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн ашигласан ус, рашааны хэмжээгээр ногдуулаагүйг аудитаар тооцсонтой холбоотой 106.4 сая төгрөг байгаа бол 2021 оны дутуу төлбөр болох 31.6 сая төгрөгийг 3 аж ахуйн нэгж 2022 онд төлж барагдуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

Баян-Овоо сумын нутагт уул, уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг "Монгол болгар гео" ХХК нь 2020-2021 онд ус ашигласны төлбөрт 51.2 сая төгрөг төлөхөөс 47.6 сая төгрөг төлж 3.6 сая төгрөгийг төлөөгүй нь Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.913, 30 дугаар зүйлийн 30.1.514 дахь заалтыг зөрчсөн байна.

Иймд ус ашигласны төлбөрийн дутуу төлбөр болох 3.6 сая төгрөгийг "Монгол болгар гео" ХХК-иар төлүүлэх төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

2.4. Ус, рашаан ашигласны төлбөрөөс байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хувь хэмжээг хуульд нийцүүлэн төлөвлөөгүй, хэрэгжүүлэх арга хэмжээг аймгийн ИТХ-аар батлаагүй байна.

2.4.1. Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хувь хэмжээг хуульд нийцүүлэн төлөвлөөгүй байна.

Монгол Улсын 2020, 2021 оны төсвийн тухай хуулиар Баянхонгор аймгийн орон нутгийн төсөвт ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоор 2020-2021 онд нийт 615.0 сая төгрөг төвлөрүүлэхээр батлагдсан байна.

Ус рашаан ашигласны төлбөрийн орлогыг аймгийн ИТХ-ын хуралдаанаас 2020 онд 450.9 сая, 2021 онд 511.0 сая нийт 961.9 сая төгрөгөөр төлөвлөж, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 2020 онд 92.7 сая, 2021 онд 122.5 сая төгрөг зарцуулахаар баталсан байна.

Аудитын илрүүлэлт:

Ус рашааны нөөц ашигласны төлбөрийн төсвийн суурь орлогыг аймгийн ИТХ-аас нэмж батлахдаа байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төсвийг нэмж хуваарилаагүй нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалтыг зөрчсөн байна.

¹³ ус ашиглах, хаягдал ус зайлуулах шаардлагыг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ус ашиглах, хаягдал ус зайлуулах эрхийг цуцлах дүгнэлт гаргах, байгальд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах;
¹⁴ ус, рашааны нөөц ашигласны болон ус бохирдуулсны төлбөр төлөх;

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ОРЛОГОД БАЙГАЛЬ ОРЧНООС ОРЖ ИРЖ
БАЙГАА ХӨРӨНГӨ ТӨВЛӨРҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ ҮР ДҮН /2020-2021/**

Хүснэгт №18. Ус рашаан ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлт, хуваарилалт /сая.төг/

Он	Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоор		Байгаль орчин нөхөн сэргээх арга хэмжээний зардалд АИТХ-аар баталсан дүн	Байгаль орчин нөхөн сэргээх арга хэмжээний зардалд батлавал зохих дүн	Дутуу баталсан дүн
	УИХ-аас баталсан	АИТХ-р баталсан			
2020	265.0	450.9	92.8	157.8	65.1
2021	350.0	511.0	122.5	178.9	56.4
Нийт	615.0	961.9	215.3	336.7	121.4

Иймд ус рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төсвийг хуваарилахдаа Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалтыг мөрдөж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

2.4.2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахдаа аймгийн ИТХ-аар батлуулаагүй байна.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 2020 онд 396.3 сая, 2021 онд 163.0 сая нийт 559.3 сая төгрөгийг зарцуулахаар аймгийн ИТХ-аас баталснаас гүйцэтгэлээр 23 төсөл, арга хэмжээнд нийт 473.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

БОАЖГ нь 2020 онд батлагдсан зардлаас 340.9 сая төгрөгийг зарцуулж 55.4 сая төгрөгийг орон нутгийн төсөв төвлөрүүлсэн бол 2021 онд 132.9 сая төгрөг зарцуулж 30.1 сая төгрөгийг байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, тайлант хугацааны зардлаар тайлагнасанд 2022 онд гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоосон байна.

Хүснэгт №19. Байгаль хамгаалах арга хэмжээний зардлаар хэрэгжүүлсэн арга хэмжээ /сая.төг/

Хэрэгжүүлсэн арга хэмжээ	2020 он	2021 он
Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага, агнуурын бүс нутгийн менежментийг хариуцагч хуулийн этгээдтэй зөвшилцөн аймгийн болон агнуурын бүс нутгийн агнуурын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ;	33.2	10.0
Усны сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагын саналыг үндэслэн “Ус” үндэсний хөтөлбөр, усны нөөцийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ;	221.2	22.0
Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага, ойн ангитай зөвшилцөн аймаг, сум, нөхөрлөлийн ойн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ;	61.6	100.9
Бусад	25.0	
ДҮН	340.9	132.9

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулсан зардлаас 448.9 сая төгрөгийг Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-д заасан төсөл, арга хэмжээнд зарцуулсан байгаа бол 2020 онд Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэгийг эко цэцэрлэг болгоход

дэмжлэг үзүүлэх зардалд 25.0 сая төгрөгийг зарцуулсан нь дээрх журмын 2.2 дахь хэсгийг зөрчсөн байна.

Мөн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төсвийг аймгийн БОАЖГ-ын төсөвт оруулан жил бүр аймгийн ИТХ-ын тогтоолоор баталж байгаа ч хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтыг аймгийн ИТХ-ын хурлаар батлуулахгүй байгаа нь Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 2.2¹⁵ дахь заалтыг зөрчсөн байна.

Иймд цаашид байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3.4 дэх заалтад нийцүүлэн төлөвлөж аймгийн ИТХ-аар батлуулж байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

2.5. Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагыг барагдуулсан ч, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

2.5.1. Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас 2019 онд “Ус, рашаан ашигласны төлбөрийн ногдуулалт, төлөлтийн байдал хууль тогтоомжид нийцэж буй эсэх”-д хийсэн нийцлийн аудитаар нийт 1,191.9 сая төгрөгийн зөрчил илэрч 139.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоон, 1,052.0 сая төгрөгийн албан шаардлага өгч хуулиар тогтоосон үүргээ биелүүлээгүй, хариуцлага алдсан холбогдох албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг аймгийн МХГ-т хүргүүлж, алдаа зөрчлийг давтан гаргуулахгүй байх 14 зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтанд өгсөн байна.

Мөн 2021 онд “Байгалын нөөц ашигласны төлбөрийн зарцуулалт, ангийн орлого, түгээмэл тархацтай ашигт малтмалын орлогын бүрдүүлэлт”-д хийсэн нийцлийн аудитаар нийт 355.4 сая төгрөгийн 17 зөрчил илэрч, 2.5 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 124.7 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 7 албан тушаалтанд 228.2 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 15 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн.

Дээрх аудитуудаар өгсөн акт, албан шаардлагыг бүрэн барагдуулж зөвлөмжөөр өгсөн зөрчлийг давтан гаргаагүй зөвлөмжийг хэрэгжүүлж байгаагаа холбогдох байгууллага, албан тушаалтнууд албан бичгээр ирүүлсэн байна.

¹⁵ Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь энэхүү журмын 2.1-д бүрдүүлсэн орлогын хэмжээнд үндэслэн тухайн жилийн төсвийн суурь зарлагын төлөвлөгөөнд дараах арга хэмжээг тусгаж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.

Гэсэн хэдий ч ус, рашаан ашигласны төлбөрийн орлогын ногдуулалтад хяналт тавиагүйгээс ус ашиглагч нь төлбөрт төлсөн дүнгээр ногдуулалтыг хийж, өр, авлагыг бүрэн тусгаагүй, зарим ус ашиглагч нь гэрээ байгуулаагүй, тоолуургүй аж ахуйн нэгжүүд дүгнэлтээр гарсан усны төлбөрийг бүрэн төвлөрүүлээгүй, ус ашиглагч ус, рашаан ашиглагчийн төлбөрийн тайланг гаргаагүй байхад орлогын гүйцэтгэлээр төлөвлөлтийг бодитой бус хийж байгаа зэргээр өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчил давтагдан гарсаар байна.

2.5.2. Өмнөх онуудад гүйцэтгэсэн дээрх нийцлийн аудитуудаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмж бүрэн биелсэн хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал байхгүй байна.

БҮЛЭГ 3. УУЛ, УУРХАЙН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ ЗАРИМ КОМПАНИ ОРЛОГЫГ ДУТУУ ТӨВЛӨРҮҮЛСЭН БАЙНА.

3.1. Уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдээс орох орлогыг бүрэн төвлөрүүлээгүй байна.

3.1.1. Уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй зарим аж ахуйн нэгж байгууллагатай хөрөнгө оруулалтын гэрээг үнийн дүнгүй байгуулсан нь цаашид орлогын төлөвлөлтөд эрсдэл үүсэхээр байна.

Аймгийн Засаг дарга нь Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1¹⁶-т заасны дагуу уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжтэй “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ” байгуулж ажилласан бөгөөд 2020 онд 8 компанитай 1,066.0 сая, 2021 онд 15 компанитай 9,130.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийх санхүүжилт олгох гэрээг байгуулсан байна.

Аудитын илрүүлэлт

Уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Ар Эс И” ХХК-тай гэрээг байгуулахдаа хөрөнгө оруулалтын үнийн дүнг тусгаагүй байхад гэрээний судалгааг авахад 1,000.0 сая төгрөгийн үнийн дүнтэй судалгаа ирүүлсэн.

Энэ талаар аймгийн ЗДТГ-ын ХБТХО-ын хэлтсийн ажил хариуцсан мэргэжилтнээс тодруулахад “анх гэрээ байгуулах үед хуульч нь төлөөлж гэрээ хийхдээ “манай захирал мөнгөн дүнтэй гэрээнд гарын үсэг зурдаггүй, хөрөнгө оруулалтын мөнгөн дүнг хавсралтаар шийднэ” гэж анх гэрээг байгуулсан боловч өнөөг хүртэл гэрээний хавсралтыг хийгээгүй” гэсэн тайлбар өгөв.

¹⁶ Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана.

Аудитаар газар дээр нь очиж тус “Ар Эс И” ХХК-аас тайлбар авахад “Манай компани 2021 онд аймаг, сумдад нийт 503.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Аймаг, орон нутгийн зүгээс 1,000.0 сая төгрөгийн гэрээ хөрөнгө оруулалт хийх шаардлага тавьж байсан боловч манай компанийн зүгээс тийм боломж байхгүй тул үнийн дүнгүй гэрээ байгуулсан” гэсэн тайлбар өгч байв.

Дээрх байдлаас үзэхэд гэрээнд заасан үнийн дүнг тодорхой заагаагүйгээс 497.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг орлого тодорхойгүй байхад зарцуулалтыг батлах эрсдэл үүсэхээр байна.

Иймд уул, уурхайн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжтэй байгуулах гэрээний хөрөнгө оруулалттай холбоотой заалтыг тодорхой тусгаж байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

3.1.2. Уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн гэрээг бүрэн дүгнээгүй, гэрээ дүгнүүлсэн компаниудаас нэг ч хуулийн этгээд хугацаагаа баримтлаагүй байна.

Уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжтэй 2020 онд байгуулсан 8 гэрээнээс 1 буюу 12.5 хувь, 2021 онд байгуулсан 15 гэрээнээс 5 буюу 33.3 хувь нь гэрээг дүгнүүлсэн, 66.7-87.5 хувь гэрээг дүгнүүлэхгүй байна.

Хүснэгт № 20. Гэрээ дүгнэсэн аж ахуйн нэгжийн жагсаалт

№	Аж ахуйн нэгжийн нэр	Гэрээний дугаар	Гэрээ байгуулсан Огноо	Гэрээ дүгнэсэн огноо	хувь
	2020 онд				
1	Наранмандал Энтерпрайзес ХХК	2021/125	2021.05.31	2022.03.21-ний өдөр дүгнэсэн. Нийт дундаж хувь байхгүй	99.0
	2021 онд				
1	Хишигт хөндий ХХК	2021/117	2021.05.25	2022.04.22-ний өдөр дүгнэсэн.	95.0
2	Наранмандал Энтерпрайзес ХХК	2021/125	2021.05.31	2022.03.21-ний өдөр дүгнэсэн. Нийт дундаж хувь байхгүй	99.0
3	Жи эс би ресурс ХХК	2021/161	2021.07.29	2022.05.30-ний өдөр дүгнэсэн.	95.5
4	Ай Эн Ди ХХК	2021/177	2021.08.17	2022.04.11-ний өдөр дүгнэсэн.	96.0
5	Топ ган дриллинг ХХК	2021/178	2021.08.17	2022.03.21-ний өдөр дүгнэсэн.	98.0

Аудитын илрүүлэлт

Уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн гэрээнд дараа оны 02 дугаар сарын 01-ний дотор гэрээний хэрэгжилтийг дүгнэхээр заасан байхад ихэнх аж ахуйн нэгжүүд гэрээг дүгнүүлээгүй, гэрээ дүгнүүлсэн компаниуд хугацаа хоцроосон байна.

Иймд “Гэрээний үүргээ биелүүлэхгүй тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тайланг ашигт малтмал газрын тосны газар хүлээн авахдаа Ашигт малтмал газрын тосны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсгийн дагуу орон нутагтай байгуулсан гэрээг дүгнэсэн актыг хавсаргаж байх зохицуулалтыг бий болгох” зөвлөмжийг Ашигт малтмал

газрын тосны газарт хүргүүлэх саналыг нэгдсэн тайланд тусгуулахаар Төв аймаг дахь Төрийн аудитын газарт уламжлав.

3.2. Уул, уурхайн үйл ажиллагааны хүрээнд төвлөрсөн орлогын эх үүсвэрээр хийсэн хөрөнгө оруулалтын үр дүнг тооцоогүй, төсвийн бүрэлдэхүүнд оруулаагүй зарцуулсан байна.

3.2.1. Гэрээнд заасан техник хяналтын зардлыг бүрэн төвлөрүүлээгүй байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хулийн 9.9¹⁷-т заасны дагуу байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлыг тухайн сумдаа байршуулсны үндсэн дээр тухайн жилийн менежментийн төлөвлөгөөг батлуулан үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна.

Харин уул уурхайн үйл, ажиллагаа, нөхөн сэргээлтэд хяналт тавих зорилгоор 1.0 сая төгрөгийн хяналтын зардлыг төвлөрүүлэхээр гэрээнд тусгасан боловч 2020 онд байгуулсан гэрээний дагуу нэг ч аж, ахуйн нэгж орлого төвлөрүүлээгүй, 2021 онд хяналтын зардлыг 16 тусгай зөвшөөрөл эзэмшигчээс 4 аж ахуйн нэгж 4.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байгаагаас харахад 2020-2021 онд техник хяналт хэрэгжүүлэх зардлын эх үүсвэр 20.0 сая төгрөгийг төвлөрүүлээгүй байна.

Иймд цаашид гэрээнд тусгагдсан техник хяналтыг зардлыг бүрэн төвлөрүүлж, уул, уурхай нөхөн сэргээлтийн хяналтын үйл ажиллагаандаа зарцуулж байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

3.2.2. Уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжээс 2020 онд 455.1 сая, 2021 онд 1,005.0 сая, нийт 1,460.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдээгүй байна.

2020 онд уул, уурхайн хамтын ажиллагааны гэрээнд заасан орлогоор 12 аж, ахуйн нэгжээс 1,200.5 сая төгрөгийн орлого оруулахаар төлөвлөснөөс 5 аж ахуйн нэгж 745.4 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна.

Хүснэгт № 21. Уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй ААН-ийн хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилт

№	Аж ахуйн нэгжийн нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	"Одод гоулд" ХХК	70.0	-	70.0	-
2	"Монгол болгар гео" ХХК	35.0	-	35.0	-
3	"Эрдэнэ цагаач" ХХК	35.0	-	35.0	-
4	"Вояжер минерал ресурс" ХХК	210.0	190.0	20.0	90.5
5	"Ай эн Ди" ХХК	42.0	-	42.0	-

¹⁷ Энэ хуулийн 9.10-т зааснаас бусад төрлийн төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлынхаа 50-иас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг тус сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлтийг жил бүр тайлагнана.

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ОРЛОГОД БАЙГАЛЬ ОРЧНООС ОРЖ ИРЖ
БАЙГАА ХӨРӨНГӨ ТӨВЛӨРҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ ҮР ДҮН /2020-2021/**

№	Аж ахуйн нэгжийн нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
6	"Мөнхийн номхон далай" ХХК	42.0	-	42.0	-
7	"Шижир аранжин" ХХК	154.0	-	154.0	-
8	"Топ ган дриллинг" ХХК	140.0	100.0	40.0	71.4
9	"Жи Эс би ресурс" ХХК	77.0	-	77.0	-
10	"Эл ти Ди" ХХК	35.0	35.0	-	100.0
11	"Наранмандал Энтерпрайзес" ХХК	220.5	335.4	(114.9)	2.1
12	"Эрдэнэ Монгол" ХХК	140.0	85.0	55.0	60.7
ДҮН		1,200.5	745.4	455.1	62.1

Эх сурвалж: 2020 оны ТЕЗ-ийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Мөн 2021 онд хөрөнгө оруулалтаар 9,130.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр гэрээ байгуулсны 5,755.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг аймагт 3375,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг сумдад хийхээр тооцсон байна. Гүйцэтгэлээр 2021-2022 онд аймагт нийт 4,750.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Хүснэгт № 22. Уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй ААН-ийн хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилт

№	Аж ахуйн нэгжийн нэр	Огноо	Байршил	Гэрээ байгуулсан дүн	Хөрөнгө оруулалтын дүн	Зөрүү
1	Шижир аранжин ХХК	2021.04.19	Галуут	300.0	210.0	90.0
2	Жи энд юу голд ХХК	2021.04.30	Гурванбулаг	1,700.0	1,700.0	-
3	Хишигт хөндий ХХК	2021.05.25	Бөмбөгөр	70.0	55.0	15.00
4	Эрдэнэ цагаач ХХК	2021.05.25	Бөмбөгөр	230.0	230.00	-
5	Ти энд ти юникс ХХК	2021.05.25	Бөмбөгөр	100.0	60.0	40.0
6	Эл Ти Ди ХХК	2021.05.31	Бөмбөгөр	100.0	100.0	-
7	Наранмандал Энтерпрайзес ХХК	2021.05.31	Баян-Овоо	1,250.0	875.0	375.0
8	Ар Эс И ХХК	2021.06.11	Галуут	1,000.0	333.5	666.5
9	Монгол болгар гео ХХК	2021.07.05	Галуут	200.0	45.6	154.4
10	Бритиш майнинг ХХК	2021.07.06	Шинэжинст	500.0	45.0	455.0
11	Эрдэнэ Монгол ХХК	2021.07.23	Шинэжинст, Баян-Өндөр	3,000.0	1,710.0	1,290.0
12	Жи эс би ресурс ХХК	2021.07.29	Гурванбулаг	130.0	50.0	80.0
13	Ай Эн Ди ХХК	2021.08.17	Бөмбөгөр	70.0	70.0	-
14	Топ ган дриллинг ХХК	2021.08.17	Галуут	450.0	450.5	(0.5)
15	Женри ХХК			30.0	15.0	15.0
ДҮН				9,130.0	5,949.6	3,180.4

Эх сурвалж: Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ээс ирүүлсэн хөрөнгө оруулалтын судалгаа

Аудитын илрүүлэлт

Уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжээс 2020 онд 455.1 сая, 2021 онд 1,005.0 сая, нийт 1,460.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдээгүй, гэрээ бүрэн хэрэгжээгүй байна.

Мөн аудитаар Баян-Овоо сумтай уул уурхай, нөхөн сэргээлтийн гэрээ хийсэн эсэх, түүний хэрэгжилтийн талаар гэрээ авах гэсэн боловч сумын Засаг дарга “Манай сум уул уурхайн орлогыг “Байшинтын таг” ОНӨААТҮГ-аар дамжуулж авч зарцуулсан. Тус байгууллагын бүх баримт материалыг АТГ хавар авсан” гэсэн тайлбар өгч цаашид шалгах боломжгүй нөхцөл байдал үүслээ.

3.2.3. Аймгийн ТЭЗ нь уул уурхайн ашиглагч компаниудтай 2021 онд 5,755.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан боловч төсөвт хандивын орлогыг 577.0 сая төгрөгөөр төлөвлөж, хөрөнгө оруулалтын орлого, зарлагыг төсвийн бүрэлдэхүүн хэсэгт тооцохгүйгээр төлөвлөж зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.3.4 дэх заалтыг зөрчсөн байна.

Уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс хөрөнгө оруулалтын хандиваар орсон 555.4 сая төгрөгийн орлогыг 2020 онд аймгийн ОНХС-д төвлөрүүлсэн бол 2020 оны 190.0 сая төгрөгийн үлдэгдлийг 2021 онд төрөх эмнэлэг болон Жаргалтай амьдрал төвийн байрны засвар тохижилтод зарцуулсан байна.

